



## ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/314

Улаанбаатар хот

### Заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүгд Найрамдах Франц Улсаас нийлүүлэгдсэн “Тусгай зориулалтын EPC 32, 42 PRX загварын автомеханик шатны автомашины ажиллагааны хугацаат үзлэг, шалгалт зохион байгуулах, техникийн үйлчилгээ хийх заавар”-ыг нэгдүгээр, “Хугацаат үзлэг, шалгалтын үеийн хөтлөх тэмдэглэл”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан заавар, тэмдэглэлийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гал түймэртэй тэмцэх газар (хурандаа Ц.Нямбаяр)-т даалгасугай.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

1426012831

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2026 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн  
1/314 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН EPC 32, 42 PRX ЗАГВАРЫН АВТОМЕХАНИК ШАТНЫ  
АВТОМАШИНЫ АЖИЛЛАГААНЫ ХУГАЦААТ ҮЗЛЭГ, ШАЛГАЛТ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ, ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү зааврын зорилго нь тусгай зориулалтын автомеханик шатны автомашины аюулгүй ажиллагаа, техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, ашиглалтын үеийн эрсдэлийг бууруулж, засвар үйлчилгээ хийх, бэлэн байдлыг хангуулахад оршино.

1.2.Энэхүү зааврыг Бүгд Найрамдах Франц Улсад үйлдвэрлэгдсэн тусгай зориулалтын EPC 32, 42 PRX загварын автомеханик шатны автомашин ашиглаж байгаа төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагууд үйл ажиллагаандаа мөрдөнө.

Хоёр. Тусгай зориулалтын автомеханик шатны  
автомашины бүтцийн ангилал, эд ангийн нэр

2.1.Автомеханик шатны автомашины бүтцийн хувьд 4 хэсэгт ангилна.

2.1.1.Үндсэн эд ангийн хэсэг (автомашины бүхээг болон арлын хэсгийг нийтэд нь хамааруулна).

2.1.2.Өргөх эргэлтийн цамхаг ба шатны хэсэг (аралд суурилсан эргэх цамхаг болон шатны хэсэг)

2.1.3.Сагсны хэсэг (шатны үзүүрт суурилсан аврах сагс)

2.1.4.Тэнцвэржүүлэх тулгуур (автомашиныг ажиллагааны бүх байрлалын үед тогтворжуулах зориулалт бүхий ачааллын тооцооллын тохируулгаар сунах хийц бүтээцийг хэлнэ).

2.2.Автомеханик шатны автомашинд удирдлагын 3 хэсэг байх бөгөөд дараах байдлаар нэрлэнэ.

2.2.1.Сагсны хэсэгт байрлах удирдлагын дэлгэц, түүний бүрдлийг аврах сагсны удирдлага;

2.2.2.Эргэх цамхагт байрлах удирдлагын дэлгэц, түүний бүрдлийг эргэх цамхагийн удирдлага;

2.2.3.Автомашины хойд хэсгийн баруун, зүүн талд байрлах удирдлагын хэсэг, тэвшний ар талд буюу голд байрлах дэлгэц, түүний бүрдлийг тэнцвэржүүлэх тулгуурын удирдлага гэж тус тус нэрлэнэ.

Гурав. Тусгай зориулалтын автомеханик шатны автомашины үзлэг,  
шалгалтын зохион байгуулалт

3.1.Автомашины ажиллагааны зүгшрүүлэлт, арал анги, тусгай тоноглолыг гадна талаас нь шалгаж, илэрсэн дутагдлыг арилгуулах, өдөр тутмын техникийн үйлчилгээний ажлыг томилгоот ээлжинд үүрэг гүйцэтгэж байгаа автомеханик шатны техникч хийнэ.

Тусгай зориулалтын автомеханик шатны автомашины ажиллагааны хугацаат үзлэг, шалгалтыг жилд 2 удаа хийх бөгөөд дараах байдлаар ангилна.

3.1.1.Хагас жилийн үзлэг (6 сар тутам);

3.1.2.Жилийн үзлэг (12 сар тутам);

3.2.Хугацаат үзлэг, шалгалтыг автын инженер, механик, автомеханик шатны техникч нар хамтран хийх бөгөөд техник, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл хариуцсан мэргэжилтэн, ангийн захирагч нар хяналт тавьж, хөтлөх тэмдэглэлийн хуудас бөглөнө.

3.3.Хугацаат үзлэг, шалгалтын үед дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.3.1.Харааны үзлэг хийх;

3.3.2.Гэрэлтүүлэх хэрэгслийг шалгах;

3.3.3.Хөдөлгөөнгүй ачааллын туршин шалгалт хийх;

3.4.Хугацаат үзлэг, шалгалтын ажиллагааны үед тусгай зориулалтын автомеханик шатны автомашинаар ачаа өргөх туршилт хийхийг хориглоно.

#### Дөрөв. Хугацаат техникийн үйлчилгээ

4.1.Тусгай зориулалтын автомеханик шатны автомашины хугацаат техникийн үйлчилгээг тухайн жилд багтаан хийж, тээврийн хэрэгслийн хувийн хэрэгт тэмдэглэнэ.

4.2.Хугацаат үзлэг, туршилтын үр дүнг үндэслэн шаардлагатай зардлыг шийдвэрлэж, засвар үйлчилгээний ажлын төлөвлөгөө боловсруулж, хийнэ.

4.3.Хугацаат техникийн засвар, үйлчилгээг шатны техникч нар хийх ба автын инженер, механик хяналт тавина.

4.4.Хугацаат техникийн засвар, үйлчилгээний үед дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.4.1.Тусгай зориулалтын автомеханик шатны автомашины багажны хайрцгийн ард байрлах удирдлагын үндсэн компьютерын чийг шингээгчийг жилд 1 удаа, батерейг 8 жилд 1 удаа, аврах сагсны хуваарилах хэсгийн хайрцгуудын чийг шингээгчийг жилд 1 удаа шалгаж, заавал солих;

4.4.2.Аврах сагсны гидравликийн шингэн тосыг жилд 1 удаа Total, Castrol, Shell 32 загварын шингэнээс сонгож 1 литр хэмжээтэй солих;

4.4.3.Өргөх эргэлтийн цамхагийн үндсэн гидравликийн шингэний савны (бак) дээд хэсэгт байрлах шүүлтүүрийг 5 жилд 1 удаа, автомашины хойд талд байрлах гар ажиллагааны удирдлага, өргөх цамхаг руу дамжуулах хоолойн нарийн шүүлтүүрийг жилд 1 удаа, гидравликийн шингэн тосыг 10 жилд хагас хэмжээгээр Total, Shell, Castrol 46 Equivis XLT 32 гэх мэт чанарын дүйцэхүйц загвараас сонгож, 80-100 литр хэмжээгээр тус тус солих;

4.4.4.Өргөх цамхагийн үндсэн цилиндрийн гол хэсэгт байрлах мэдрэгчийн гинжийг WVD 6 загварын тос ашиглаж, тосолгоог хийх;

4.4.5.Ослын үед ашиглах зориулалтын 24 вольтын цахилгаан хөдөлгүүрийн тосыг 10 жилд 1 удаа SP 150 загварт дүйцүүлж, солих;

4.4.6.Цаг уурын хуурай уур амьсгалтай нөхцөлд бүх цэгийн тосолгооны шаардлагатай автомашины бүхээгийн ард байрлах тосолгооны цэгийн хошуу, тэнцвэржүүлэх 4 тулгуурын цилиндр, сунах үеийн чиглүүлэгч, өргөх

цамхагийн үндсэн 2 цилиндр, хойд тэнхлэгийн түгжих механизм, хэсгүүдэд 6 сард 1 удаа үзлэг, шалгалт, тосолгоо хийх;

4.4.7.Шатны үе дагасан цахилгааны утас EPC 32 PRX - 46 м, бүрхүүлд тогтсон тосыг арилгах, цэвэрлэх;

4.4.8.Аккумуляторын холболтын толгойд зэврэлт, бохирдол, хэлбэрийн алдагдал үүссэн бол цэвэрлэх;

4.4.9.Өргөх цамхагийн ган татлагын (тросс) суналт, агшилтын гадна үзлэгийг тогтмол хийж, хүйтний улиралд суллаж, дулааны улиралд чангалах тохиргоог хийх;

4.4.10.Гэрэлтүүлэх хэрэгслүүд шатсан бол солих;

Тав. Хөдөлгөөнгүй ачааллын шалгалт хийх аргачлал

Тусгай зориулалтын EPC 32, 42 PRX загварын автомеханик шатны автомашины хугацаат үйлчилгээний үеийн хөтлөх тэмдэглэлийн заалтын дагуу үзлэг хийж, шалгана.

5.1.Хөдөлгөөнгүй ачааллын туршилт:

5.1.1.Тэнцвэржүүлэх 4 тулгуурыг бүрэн сунгаж, сагсыг дээд хүчин чадлаар буюу 1 хүнийг 110 кг жингээр тооцож, 440 кг ачааг байрлуулна.

5.1.2.Сагсыг 180° буюу автомашины ард тал руу эргүүлж, 45° -ын налуугаар ажиллах бүсийн хязгаар хүртэл сунгаж, байрлуулан хөдөлгүүрийг унтраана.

5.1.3.Өргөх үндсэн цилиндр дээр маркераар тэмдэглэж, зургаар баримтжуулна.

5.1.4.Дэлгэц дээр заагдсан өндөр, суналтын уртын хэмжилтийг тэмдэглэн авч, 15 минутын хугацаанд тус байрлалд үлдээнэ.

5.1.5.Заасан хугацаа өнгөрсний дараа өргөх үндсэн тэгшлэх цилиндрүүд дээрх болон дэлгэц дээрх заалтуудыг урьд тэмдэглэж авсан баримтуудтай харьцуулан өөрчлөлт байгаа эсэхийг шалгаж, баримтжуулна.

5.1.6.Хөдөлгүүрийг асааж, ачааг буулгаж, шатыг хэвийн байрлалд оруулна.

Зургаа. Туршин шалгалтын үр дүн


6.1.Туршин шалгалтын үр дүнг хөтлөх тэмдэглэлийг үндэслэн холбогдох удирдлагад дэлгэрэнгүй илтгэх хуудсаар танилцуулж, баталгаажуулах ба засвар үйлчилгээ хийх шаардлагатай тохиолдолд томилгоот хуваариас хасч болно.

6.2.Засвар, үйлчилгээнд шаардагдах зардлыг шийдвэрлүүлэх талаар харъяа нэгжийн удирдлагад танилцуулах ба нэн даруй шийдвэрлэж, бэлэн байдлыг хангуулна.

6.3.Эвдрэл, гэмтэл, доголдол үүссэн эд анги болон бусад эргэлзээтэй асуудал үүссэн нөхцөлд үйлдвэрлэгч эсхүл албан ёсны төлөөлөгчид мэдэгдэнэ.

6.4.Туршилтын явцад болон туршилтын үр дүнг зургаар баталгаажуулж, баримтыг хавсаргана.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2026 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн  
1/34 дугаар тушаалын 02 дугаар хавсралт



## ХУГАЦААТ ҮЗЛЭГ, ШАЛГАЛТ ХИЙХ ҮЕИЙН ХӨТЛӨХ ТЭМДЭГЛЭЛ

### Ерөнхий мэдээлэл

Ашиглагч байгууллагын нэр: .....  
Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар: .....  
Загвар, тусгай тоноглолын хувийн дугаар: .....  
Арлын дугаар: .....  
Км-ийн гүйлт (спидометр): .....  
Хөдөлгүүр, тусгай тоноглолын ажилласан  
мотоцаг: .....  
Огноо: .....

| д/д                                                          |                                                                                                                                                                   | Хугацаат үзлэгийн ажиллагааны төрөл, ангилал | Төлөв байдлын нийцэл             |                                                                 |
|--------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------|----------------------------------|-----------------------------------------------------------------|
|                                                              |                                                                                                                                                                   |                                              | Хэвийн<br>(Ашиглах<br>боломжтой) | Хэвийн бус<br>(илрүүлсэн эсхүл<br>мэдэгдэхүйц<br>нөхцөл, утгыг) |
| 1. Харааны үзлэг:                                            |                                                                                                                                                                   |                                              |                                  |                                                                 |
| Үндсэн эд ангийн хэсгийн харааны үзлэг:                      |                                                                                                                                                                   |                                              |                                  |                                                                 |
| 1.1                                                          | 1.1.1. Аккумуляторын холболтын толгойн бүрэн бүтэн байдал, зэврэлт, хэлбэр алдалт үүссэн эсэх;                                                                    |                                              |                                  |                                                                 |
|                                                              | 1.1.2. Арал, түүний дээр бэхлэгдсэн эд ангиудад цууралт, гагнаас салсан эсэх;                                                                                     |                                              |                                  |                                                                 |
|                                                              | 1.1.3. Бүх өндөр даралтын гидрийн шингэний дамжуулах хоолойд (бүхээгийн ард 1, гар ажиллагааны горимын удирдлага, тэнцвэржүүлэх тулгууруудын) алдалт байгаа эсэх; |                                              |                                  |                                                                 |
|                                                              | 1.1.4. Хойд тэнхлэгийн түгжих механизмын татуурга ба гинжийг шалгах;                                                                                              |                                              |                                  |                                                                 |
|                                                              | 1.1.5. Эргэлтийн цамхгийн цахилгааны дамжуулах утас, тогтмол гүйдлийн тэжээлийн холболт болон шат дагасан цахилгааны утас, бүрхүүл, хэвийн эсэх;                  |                                              |                                  |                                                                 |
|                                                              | 1.1.6. Гидравлик тосны төвшин хэвийн эсэх (Аяны байрлалд байгаа үед шалгана);                                                                                     |                                              |                                  |                                                                 |
|                                                              | 1.1.7. Механик ажиллагааны гидравлик хуваарилагчийн төлөв байдлын хяналт шалгалт (Гар ажиллагааны татуургууд)                                                     |                                              |                                  |                                                                 |
|                                                              | 1.1.8. Тэнцвэржүүлэх тулгуурын удирдлагын хэсгийн ажиллагаа хэвийн эсэх;                                                                                          |                                              |                                  |                                                                 |
| 2. Өргөх эргэлтийн цамхаг болон шатны хэсгийн харааны үзлэг: |                                                                                                                                                                   |                                              |                                  |                                                                 |
| 2.1                                                          | 2.1.1. Өргөх эргэлтийн цамхагийн удирдлагын ажиллагаа хэвийн эсэхийг шалгах;                                                                                      |                                              |                                  |                                                                 |
|                                                              | 2.1.2. Шатны татлага троссын чангалгааны 16 ширхэг бул, тэнхлэг, түгжээг шалгах;                                                                                  |                                              |                                  |                                                                 |
|                                                              | 2.1.3 Шатны суналт, эвхэх үеийн хөндлийн хязгаарлах 16 ширхэг мэдрэгч, тэнцвэржүүлэх                                                                              |                                              |                                  |                                                                 |

|                                        |                                                                                                                                                                                       |  |  |
|----------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|
|                                        | тулгууруудын хураах мэдрэгчүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгах;                                                                                                                         |  |  |
|                                        | 2.1.4. Өргөх цилиндрийн нугасны 14 ширхэг, шатны ролик доод талд 30 ширхэг, хажуу талд 6 ширхэг, гол, тэнхлэг болон түгжээнүүдийг (шплинт) шалгах;                                    |  |  |
|                                        | 2.1.5. Бүх төрлийн мэдрэгчийн цахилгаан дамжуулах утас болон сагсны цахилгаан хангамжийн тэжээлийн холболт (залгуур гэх мэт) дагалдах хэрэгслүүдийг шалгах;                           |  |  |
| 3. Аврах сагсны хэсгийн харааны үзлэг: |                                                                                                                                                                                       |  |  |
| 3.1                                    | 3.1.1. Удирдлагын ажиллагаа, мэдрэгчийн хэвийн эсэхийг шалгах;                                                                                                                        |  |  |
|                                        | 3.1.2. Хамгаалалтын бүсний бэхэлгээний хэвийн байдлыг шалгах;                                                                                                                         |  |  |
|                                        | 3.1.3. Сагсны хаалгануудын ажиллагааг шалгах; (сагс хураах болон аврагч нэвтрэх үед)                                                                                                  |  |  |
|                                        | 3.1.4. Ослын үеийн ажиллагааны насосны хөшүүрэг байгаа эсэхийг шалгах;                                                                                                                |  |  |
|                                        | 3.1.5. Зайн 3 мэдрэгчүүдийн ажиллагааг шалгах;                                                                                                                                        |  |  |
|                                        | 3.1.6. Суурин лафетны хошууны ажлын байрлалууд, цахилгааны дамжуулах утасны бүрэн бүтэн байдал, алсын зайн 2 ширхэг удирдлагын ажиллагаа, холбох шугамын хоолойн холболтуудыг шалгах; |  |  |
| 4. Гэрэлтүүлэх хэрэгслийн үзлэг:       |                                                                                                                                                                                       |  |  |
| 4.1                                    | 4.1.1. Үндсэн эд ангийн хэсгийн гэрэлтүүлэх хэрэгсэл:                                                                                                                                 |  |  |
|                                        | 4.1.2. Холын болон ойрын гэрлийн 4, дуут дохионы 3, гэрэл дохионы 4, оврын 7 ширхэг гэрэл, ухрахын 2 ширхэг гэрэл зэрэг үндсэн 20 ширхэг гэрлүүд;                                     |  |  |
|                                        | 4.1.3. Тэнцвэржүүлэх тулгууруудын тус бүр 1 буюу нийт 4 ширхэг, 2 талын хөшигний 10 ширхэг лед гэрэлтүүлгийн ажиллагаа;                                                               |  |  |
|                                        | 4.1.4. Өргөх эргэлтийн цамхаг болон шатны хэсэг:                                                                                                                                      |  |  |
|                                        | 4.1.5. Өргөх эргэлтийн цамхагийн гэрэлтүүлэг;                                                                                                                                         |  |  |
|                                        | 4.1.6. Шатны хажуугийн 360°-ын 2, холын тусгалтай лед 2, суудлын арын 3, баруун талд 1, гишгүүр дор 2 нийт 10 ширхэг гэрэлтүүлэг;                                                     |  |  |
|                                        | 5. Сагсны хэсэг:                                                                                                                                                                      |  |  |
| 5.1                                    | 5.1.1. Сагсны урд талд 2, доод 1, суурилсан холын тусгалтай лед 2, ажиллагааны 3 ширхэг буюу нийт 8 ширхэг гэрлийн ажиллагаа;                                                         |  |  |
| 6. Хөдөлгөөнгүй ачааллын туршилт:      |                                                                                                                                                                                       |  |  |
| 6.1                                    | 6.1.1. Заасан хугацаа өнгөрсний дараа өргөх үндсэн тэгшлэх цилиндрүүд дээрх болон дэлгэц дээрх заалтуудыг урьд тэмдэглэж авсан баримтуудтай харьцуулан өөрчлөлт байгаа эсэх;          |  |  |